



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн шатанд хийсэн аудитын дүнгийн талаар	8
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5	Хавсралт.....	19
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.ЦАГААНХҮҮ ТАНАА

2019.03.25 № 01/583
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Н.Цагаанхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 19-нөөс 2019 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай, аудитор Ц.Цэрэнхүү, гэрээт аудитор Б.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэв.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/689 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБООУС, АООУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад, дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын нутаг дэвсгэрт хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх эрх зүйн таатай орчныг бий болгох, хууль тогтоомж, стандарт хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Үйл ажиллагааныхаа зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай зэрэг хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Эмералд” програм хангамж ашигладаг байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дотоод аудитын алба харъяа 4 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт 4.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, уг зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь 38,060.4 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 761.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн нэгтгэсэн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2.0 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 26 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аудитад бүрэн хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	23	1	3	0
	Дүн	23	1	3	0

Аудитаар 20 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 3 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал, дүгнэлт өгч, 1 байгууллага түүвэрт хамрагдаж, 3 байгууллагын санхүүгийн тайланд хараат бус аудитын компани аудит хийсэн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 648.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	56	623.8	12	23.6	16	339.8	28	260.4	-	-	-	-
2	ТТЗ	2	24.9			1	11.9	1	13.0	-	-	-	-
	Дүн	58	648.7	12	23.6	17	351.7	29	273.4	-	-	-	-

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн шатанд хийсэн аудитын дүнгийн талаар

Дундговь аймгийн МХГ нь төсвийн хэмнэлтээс ахмадын санд хөрөнгө төвлөрүүлэхдээ хуульд заасан хувь хэмжээнээс илүү төвлөрүүлсэн, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа, лаборатори нь үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой тооцож төлөвлөдөггүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан, шинжилгээний өр төлбөрийн авлагыг барагдуулаагүй, Буянт ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь төсвийг үргүй зарцуулсан, ажиллагсад ээлжийн амралт олгохдоо унаа, хоолны мөнгийг дундаж цалинд оруулан тооцож олгосон зэрэг зөрчлүүд илэрч “Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан байна.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгасан болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад асуудал гараагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт чиг үүргээ хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан 32,568.8 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Зардлын нийт гүйцэтгэл 30,658.2 сая төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 584.0 сая, байр ашиглалтын зардлыг 123.8 сая, хангамж бараа материалын зардлыг 55.2 сая, нормативт зардлыг 23.3 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 17.6 сая, томилолтын зардлыг 17.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийн зардлыг 94.3 сая, бараа ажил, үйлчилгээний бусад зардлыг 9.5 сая, тэтгэвэр, тэтгэмж, урамшууллын зардлыг 15.8 сая, хөрөнгийн зардлыг 514.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу сар бүр төсвийн гүйцэтгэл, 5 саяас дээшхи мөнгөн болон хөрөнгийн шинжтэй худалдан авалтын гүйлгээг тогтмол мэдээлж, ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдэгдлийг тендерийн үнэлгээний хороонд ажилласан гишүүн бүрээр гаргуулж, холбогдох албан тушаалтанд тайлагнан ажилласан байна.

Санхүү, төсөв, хөрөнгөтэй холбоотой тушаал, шийдвэр, төсвийн тодотгол, хуваарь, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, хандив тусламжийн талаарх мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн явцын мэдээлэл, бүтэц, орон тооны өөрчлөлт зэргийг тухай бүрт нь хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь 2018 онд мэдээлбэл зохих 146 мэдээнээс 139 мэдээг хугацаанд нь, 7 мэдээг хугацаа хоцроосон байна.

Төв, орон нутаг дахь Мэргэжлийн хяналтын нэгжүүдийн шилэн дансанд улирал бүр хяналт тавьж, гарсан алдаа зөрчлийн талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 1/1145 дугаар албан бичгээр мэдэгдэж, зөрчлийг арилгуулан ажилласан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна.

Зөвлөмжийн мөрөөр он дамжсан 50.9 сая төгрөгийн авлагаас 10.9 сая төгрөгийг барагдуулж, үлдэх эзэн холбогдогчгүй авлагыг хууль хяналтын байгууллагад хандаж, шийдвэрлүүлэхээр асуудал тавьсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна. Цаашид уг авлагыг барагдуулах талаар албан шаардлага өглөө.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийг тулган шалгахад он дамжсан, холбогдогч байгууллага нь дампуурсан, иргэн нь нас барсан, мөн эзэн холбогдогч нь тодорхой бус зэрэг 11.9 сая төгрөгийн авлагыг өнөөг хүртэл барагдуулж, шийдвэрлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдээдлийг тооцсон байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл: Өр, авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байх,

Зөвлөмж: Авлагыг барагдуулах талаар албан шаардлага өгөх;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн.

2. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн зориулалтыг зөрчин урсгал зардлаас 12.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх;

Зөвлөмж: Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31-ны өдөр	2018 оны 12-р сарын 31-ны өдөр
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,712,750.33	4,070,334.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	45,844.46	149,260.25
33	АВЛАГА	50,979.64	57,915.12
34	УРЬДЧИЛГАА	-	5,560.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,090,923.61	2,801,355.80
36	НӨӨЦИЙН БАРАА	3.50	3.50
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	524,999.13	1,056,240.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,170,645.92	31,577,463.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,170,645.92	31,577,463.80
39200	Биет хөрөнгө	29,893,067.02	29,850,365.18
39300	Биет бус хөрөнгө	277,578.90	1,727,098.61
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	32,883,396.26	35,647,798.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,375.56	128,827.25
41300	Өглөг	10,875.56	163.23
41400	Урьдчилж орсон орлого	15,500.00	128,664.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,857,020.70	35,518,971.21
51	Засгийн газрын хувь оролцоо	32,857,020.70	35,518,971.21
51100	Засгийн газрын оруулсан капитал	14,959,804.46	16,432,657.26
51200	Хуримтлагдсан үр дүн	16,327,232.97	16,077,223.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,569,983.27	3,009,090.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,883,396.26	35,647,798.46

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	37,560,274.46	37,751,816.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,766,032.91	5,260,509.69
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,794,241.56	32,491,306.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,967,853.04	31,446,435.97
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	772,248.87	1,037,209.58
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	54,139.64	7,660.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	36,757,772.07	36,942,404.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,084,726.63	36,736,946.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,107,387.67	31,220,204.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,720,498.89	19,209,310.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,067,386.23	2,313,161.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,416,364.98	1,543,983.77
2104	Хангамж, бараа материалын зардал	1,204,157.06	1,175,026.71
2105	Нормативт зардал	484,081.31	440,336.55
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	260,115.08	478,245.62
2107	Томилолт, зочны зардал	406,335.16	447,234.49
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	441,628.95	740,096.24
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,106,820.02	4,872,809.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,977,338.96	5,516,741.76
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	673,045.44	205,458.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	802502.397.16	809,411.74
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,321,262.45	1,118,035.93
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-518,760.05	-308,624.20

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	32,056,639.39	36,367,789.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,151,952.71	3,884,144.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,904,686.67	32,483,645.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,967,853.04	31,446,435.97
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	772,248.87	1,037,209.58
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	164,584.76	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,489,918.16	33,011,717.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,489,918.16	33,011,717.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,380,552.17	27,475,958.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,718,396.13	19,211,834.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,062,052.39	2,316,085.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,471,795.52	1,550,266.47
2104	Хангамж, бараа материалын зардал	857,903.85	1,160,446.36
2105	Нормативт зардал	568,681.85	835,237.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	241,757.20	850,023.88
2107	Томилолт, зочны зардал	412,803.42	461,264.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	511,917.03	777,576.41
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	535,244.77	313,222.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,109,365.99	5,535,759.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	566,721.23	3,356,072.29
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	595,869.68	3,252,656.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	595,869.68	3,252,656.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-595,869.68	-3,252,656.50
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-29,148.45	103,415.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,992.90	45,844.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,844.46	149,260.25

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Цэвэр хөрөнгө/ өмчийн дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,384,709.68		33,384,709.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,928.93		-8,928.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,375,780.75		33,375,780.75
Тайлант үеийн үр дүн	-518,760.05		-518,760.05
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,857,020.70		32,857,020.70
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	32,857,020.70		32,857,020.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-131,700.00		-131,700.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	32,725,320.70		32,725,320.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,629,421.90		1,629,421.90
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,472,852.80		1,472,852.80
Тайлант үеийн үр дүн	-308,624.20		-308,624.20
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,518,971.21		35,518,971.21

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,562,810.6	30,658,184.4	1,904,626.2	94.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,564,588.2	28,623,381.6	941,206.6	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,818,166.1	27,892,429.2	925,736.9	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,670,743.7	19,130,274.2	540,469.5	97.3
210101	Үндсэн цалин	15,019,469.3	14,585,916.8	433,552.5	97.1
210102	Нэмэгдэл	2,788,487.6	2,726,316.3	62,171.3	97.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,083,874.0	1,045,755.6	38,118.4	96.5
210104	Урамшуулал	-	12,042.3	(12,042.3)	0.0
210105	Гэрээт ажлын хөлс	778,912.8	760,243.2	18,669.6	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,359,710.9	2,316,085.9	43,625.0	98.2
210201	Тэтгэврийн даатгал	1,573,412.7	1,566,359.3	7,053.4	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	196,574.4	185,399.0	11,175.4	94.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	157,259.9	151,656.6	5,603.3	96.4
210204	Ажилгүйдлийн даатгал	39,314.6	38,768.9	545.7	98.6
210205	Эрүүл мэндийн даатгал	393,149.3	373,902.2	19,247.1	95.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,674,138.7	1,550,266.5	123,872.2	92.6
210301	Гэрэл, цахилгаан	233,256.6	238,407.9	(5,151.3)	102.2
210302	Түлш, халаалт	736,220.8	695,746.5	40,474.3	94.5
210303	Цэвэр, бохир ус	163,353.0	128,555.7	34,797.3	78.7
210304	Байрны түрээс	541,308.3	487,556.3	53,752.0	90.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,204,448.0	1,149,222.4	55,225.6	95.4
210401	Бичиг хэрэг	254,421.2	252,664.3	1,756.9	99.3
210402	Тээвэр, шатахуун	545,667.8	520,804.9	24,862.9	95.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	306,199.4	278,062.3	28,137.1	90.8
210404	Ном, хэвлэл	60.0	40.0	20.0	66.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,997.6	5,571.2	(573.6)	111.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	93,102.0	92,079.7	1,022.3	98.9
2105	Нормативт зардал	827,042.0	803,769.8	23,272.2	97.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	739,549.4	727,629.5	11,919.9	98.4
210502	Хоол, хүнс	77,539.6	69,670.3	7,869.3	89.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,953.0	6,470.0	3,483.0	65.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,662,869.5	1,645,215.0	17,654.5	98.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	762,969.2	748,757.7	14,211.5	98.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	407,095.8	388,878.0	18,217.8	95.5
210604	Урсгал засвар	492,804.5	507,579.2	(14,774.7)	103.0
2107	Томилолт, зочны зардал	443,153.5	425,433.8	17,719.7	96.0
210701	Гадаад албан томилолт	13,000.0	12,891.1	108.9	99.2
210702	Дотоод албан томилолт	428,203.5	410,600.7	17,602.8	95.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,950.0	1,942.0	8.0	99.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	830,888.3	736,538.3	94,350.0	88.6

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,522.6	458,030.4	45,492.2	91.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,156.0	5,909.4	3,246.6	64.5
210803	Даатгалын үйлчилгээ	30,919.3	24,284.3	6,635.0	78.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	13,155.9	9,829.2	3,326.7	74.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,800.0	2,593.3	206.7	92.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	134,702.8	122,018.9	12,683.9	90.6
210807	Газрын төлбөр	8,362.0	6,017.1	2,344.9	72.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	128,269.7	107,855.7	20,414.0	84.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,171.5	135,623.3	9,548.2	93.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	145,171.5	135,623.3	9,548.2	93.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	746,422.1	730,952.4	15,469.7	97.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	746,422.1	730,952.4	15,469.7	97.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	133,709.0	132,545.2	1,163.8	99.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	612,713.1	598,407.3	14,305.8	97.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,998,222.4	2,034,802.8	963,419.6	67.9
220001	Барилга байгууламж	2,690,922.4	1,738,234.7	952,687.7	64.6
221001	Их засвар	107,300.0	96,708.1	10,591.9	90.1
222001	Тоног төхөөрөмж	200,000.0	199,860.0	140.0	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,562,810.6	30,658,184.4	1,904,626.2	94.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,409,855.6	30,505,229.4	1,904,626.2	94.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	32,409,855.6	30,505,229.4	1,904,626.2	94.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	152,955.0	152,955.0	-	100.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	152,955.0	152,955.0	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10.0	(10.0)	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10.0	(10.0)	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	4,171	4,089	82	98.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	27	27	0	100.0
610001	Төсвийн байгууллага	27	27	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2,072	2,031	41	98.0
620001	Удирдах ажилтан	34	34	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,585	1,530	55	96.5
620003	Үйлчлэх ажилтан	305	311	-6	102.0
620004	Гэрээт ажилтан	148	156	-8	105.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2,072	2,031	41	98.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,521	1,466	55	96.4
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	2	2	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	549	563	-14	102.6

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит	Аудитын код:
2019.03.25			САГ-2019/4/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан			Алдаа, зөрчилтэй асуудал	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5			9	10
1	Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийг тулган шалгахад он дамжсан, эзэн холбогдогч байгууллага нь дампуурсан, иргэн нь нас барсан, мөн эзэн холбогдогч нь тодорхой бус зэрэгтэй холбоотой авлагыг өнөөг хүртэл барагдуулж, шийдвэрлээгүй байна.	11.9	Албан шаардлага өгөх.			Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Цагаанхүү С.Бадамцэцэг
2	Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас/бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж/ хөрөнгө бэлтгэсэн.	12.9	Зөвлөмж өгөх.			Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Цагаанхүү С.Бадамцэцэг
	Нийт	24.8					